



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/25


Улаанбаатар хот

Тэмцээнд оролцуулах тухай

Нийслэлийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот, ОХУ-ын Сургуулийн сагсан бөмбөгийн лиг “КЭС-Баскет” байгууллагын хооронд байгуулсан хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын ахлах мэргэжилтэн А.Болдмаа ахлагчтай өсвөрийн сагсан бөмбөгчдийн 25 хүний бүрэлдэхүүнтэй баг тамирчдыг ОХУ-ын Москва хотод болох ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сагсан бөмбөгийн “Сурагчдын лиг” супер финалын тэмцээнд 2014 оны 04 дүгээр сарын 03-19-ны өдрүүдэд оролцуулсугай.
2. Тэмцээнд оролцох баг тамирчдын зардлыг хавсралтаар баталсугай.
3. Тэмцээнд оролцоход шаардагдах нийт 10.477.500 /арван сая дөрвөн зуун далан долоо таван зуун/ төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын орон нутгийн төвлөрсөн арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодогч О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.
4. Тэмцээнд оролцох бэлтгэл ажлыг хангаж, баг тамирчдыг оролцуулахыг ахлах мэргэжилтэн А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА




Ж.ГАНБОЛД

Tushaal 2014

1150500055

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2014 оны дөрөвдүгээр сарын 01-ний өдрийн
4/25 дугаар тушаалын хавсралт



Тэмцээнд оролцох тамирчдын зардлын төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн
1.	Галт тэрэгний зардал: Улаанбаатар– Москва-Улаанбаатар 419.100 /төг/х 25 хүн = 10.477.500 төг	10.477.500 төг
ДҮН:		10.477.500 төг